



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/46/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: Bulgan@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Утас:9907-9641 Цахим хаяг: Tserenkhamg@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 211

танай _____ ны № _____ Т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

"Хутаг-Өндөрийн сэргэлт" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд улсын

6326050439



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 211

танай _____ ны № _____ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

"Хутаг-Өндөрийн сэргэлт" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд улсын

6326050439

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		(мянган төгрөгөөр)	
Үзүүлэлт		2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	131,578.2	157,224.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,103,450.5	5,164,806.4
	Нийт хөрөнгийн дүн	4,235,028.7	5,322,031.1
	Нийт өр төлбөрийн дүн	2,925.8	7,000.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,232,102.9	5,315,031.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,235,028.7	5,322,031.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,611,406.8	2,732,146.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,601,704.4	1,642,777.6
	Үйл ажиллагааны үр дүн	1,009,702.4	1,089,369.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	(21,522.9)	(5,438.9)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	988,179.5	1,083,930.3
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,243,923.5	4,232,102.9
	Тайлант оны үр дүн	988,179.4	1,082,928.1
	Эцсийн үлдэгдэл	4,232,102.9	5,315,031.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,361,488.1	1,212,513.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,270,075.6	1,172,002.5
	Үйл ажиллагааны ЦМГ	91,412.5	40,510.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(91,401.9)	(40,521.1)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	10.6	(10.6)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10.6	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	1,179,364.5
	Урсгал зардал	-	1,179,364.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,179,364.5
	Улсын төсвөөс санхүүжих	-	1,179,364.5
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хутаг-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилгоо “Иргэдэд төрийн үйлчилгээг хурдан, шуурхай, чанартай хүргэж, төрийн захиргааны манлайлагч байгууллага байх нь бидний эрхэм зорилго” гэж тодорхойлсон байна. Харин 2025 оныг “Тогтвортой хөгжил, хариуцлагатай төрийн алба” зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхээр “Хутаг-Өндөрийн сэргэлт” засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр дараах зорилтыг хүрээнд ажилласан байна

“Хутаг-Өндөрийн сэргэлт” үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хүний хөгжлийн бодлого, Эдийн засаг, Ногоон хөгжил, Дэд бүтэц, Засаглалын бодлого, Амар тайван аюулгүй нийгэм, Бүс орон нутгийн бодлого гэсэн арга хэмжээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллажээ.

Байгууллагын зохистой засаглал, дотоод хяналтын байдал, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, сумын Засаг даргын 2025 оны А/439 дүгээр захирамжаар 87.5 хувьтай үнэлүүлэн “маш сайн” үнэлгээ авсан байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Авилгын эсрэг хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, тогтоомж, Сангийн сайдын холбогдох журам, заавруудыг мөрдлөг болгон ажилласан байна.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хууль,
- Сумын ИТХ-ын холбогдох тогтоолууд,
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ. Тайлант онд хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, “Төсвийн сахилга бат, хариуцлагыг

чангатгах тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Нийгмийн халамж, цалин хөлстэй холбоотой 2025 онд төрийн албан хаагчийн цалин, тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн, "Эхийн алдар" одонтой эхийн мөнгөн тэтгэмжийг хоёр дахин нэмэгдүүлсэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, 792.0 мянган төгрөг болгосон, ахмад настны тухай хуульд ахмад настан хөдөлмөрийн гэрээгээр ажиллах тохиолдолд тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болох хууль, эрх зүйн өөрчлөлт мөрдөгдөж эхэлсэн байна.

Тав. Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

"Хутаг-Өндөрийн сэргэлт" үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн албан хаагчийн 8 айлын орон сууц, Орон нутгийн хөгжлийн сангаас хүүхдийн тоглоомын талбай, мах борлуулах цэг зэрэг нийт 1,490.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч бүртгэж тайлагнасан байна.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн, батлагдсан төсвийг мянган төгрөгөөр мэдээлсэн, байгууллагын ерөнхий мэдээлэл дутуу, хавсралт файлыг холбогдох мэдээллийн нотлох баримтыг дутуу, хангалтгүй мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Албан хэрэг хөтлөлтийн үнэт цаасны тайлан гаргаагүй, архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулж, цахим архивын нэгж үүсгэж ажиллаагүй байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4-т "архивын баримтыг холбогдох журам, стандартын дагуу хадгалах, хамгаалах", 23.2.6-д "архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан бүрдүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг зохион байгуулалтын нэгж, ажилтнаас иж бүрэн хүлээн авах, архивын баримтыг эмхлэн цэгцлэх, ангилан төрөлжүүлэх, баримтыг холбогдох журам, стандартын дагуу үдэж, хаягжуулах, архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн санг бүрдүүлэх талаар зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох хуулийн заалт, шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сумын Засаг даргын тамгын газрын дансанд бүртгэлтэй, Илчит хутаг ОНӨХХК болон бусад байгууллагын эзэмшдэг хөрөнгүүд бүртгэлтэй байна.

Иймд дараагийн анхаарах асуудлаар сумын хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар сумын ИТХ-аар хэлэлцүүлэн, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэхэд анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 38.6 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 38.9 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 42.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3.4 сая төгрөгөөр дутуу байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшлын 42 нэр төрлийн хөрөнгийн 38.6 сая төгрөгийн элэгдлийн зардлыг тайлант хугацаанд дутуу тайлагнасан байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн, аймгийн Засаг даргад хүргүүлэн шийдвэрлүүлэн бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшилын 42 нэр төрлийн хөрөнгийн 38.6 сая төгрөгийн элэгдлийн зардлыг тайлант хугацаанд дутуу тайлагнасан байна.	1	38.9					1	38.9				
Дүн	1	38.9					1	38.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн	1	-					1	-

мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн, батлагдсан төсвийг мянган төгрөгөөр мэдээлсэн, байгууллагын ерөнхий мэдээлэл дутуу, хавсралт файлыг холбогдох мэдээллийн нотлох баримтыг дутуу, хангалтгүй мэдээлсэн байна.								
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Албан хэрэг хөтлөлтийн үнэт цаасны тайлан гаргаагүй, архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулж, цахим архивын нэгж үүсгэж ажиллаагүй байна.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Нийт дүн	2	-					2	-